



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.06.09 № 01/56 ЧАТ/ТАТ/2014/37 НТТ

Зөрчлийг арилгуулах тухай

Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан” 2013 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан орлогын төлөвлөгөөг 688.7 сая төгрөгөөр биелүүлээгүй зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил нь 97 аж ахуйн нэгж, байгууллагын 845.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүйтэй холбоотой байна.

Мөн Харилцаа холбооны зохицуулах хороо аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрлийг сунгах болон аж ахуйн нэгж, байгуулагад хийх шалгалтандаа орлого төвлөрүүлсэн эсэхийг харгалзан үздэггүй, “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан”-тай харилцан уялдаатай ажилладаггүй, сангийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актуудын зарим заалт өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх” гэж заасныг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Б.Балгансүрэнгээс дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ШААРДАХ нь:

1. 2013 онд тооцоо нийлж авлагаар бүртгэгдсэн 97 аж ахуйн нэгж, байгууллагаас авах 845.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авах.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хийсэн гэрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.2-т заасан орлогыг улсын төсөвт бүрэн төлж байх талаарх заалтыг нэмэлтээр оруулж бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулан ажиллах.
3. Зөрчлийг арилгуулах талаар авсан арга хэмжээний тухай хариуг 2014 оны 12 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

АУДИТОР
АУДИТОР

Ц.ЦОЛМОН
Д.НЯМХҮҮ

УХА0122

Хувийг: